



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,

Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,

Утас/Факс: (976) 7033 3141,

Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2024.11.20 № 468

танай _____-ны № _____-т

ГҮЙЦЭТГЭЛ, НИЙЦЛИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.ЭНХБОЛД ТАНАА

Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан
нэгдсэн төлөвлөгөөний дагуу “Төрийн байгууллагын хүний
нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө”-нд хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайланг хүргүүлж байна.

Хавсралт ⁴⁰ хуудастай

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.БАЙГАЛМАА





АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ
ХӨТӨЛБӨРИЙГ БАТЛААГҮЙ, ХЯНАЛТЫН ҮР НӨЛӨӨТЭЙ ТОГТОЛЦОО
БҮРДЭЭГҮЙ БАЙНА

АУДИТЫН НЭР: ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН
БОДЛОГО, ТОГТОЛЦООНЫ ҮР НӨЛӨӨ

АУДИТЫН КОД: АРА-2024/19-01-ШТА-ГА

Архангай аймаг 2024 он



Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх
аудитор Т.Байгалмаа

Утас: 77333141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 77332860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Цог-Эрдэнэ

Утас: 99210906 Цахим хаяг: Tsogerdeneg@audit.gov.mn

Аудитор Н.Энхчимэг

Утас: 89891150 Цахим хаяг: Enkhchimegn@audit.gov.mn

Аудитор А.Пүрэвцэцэг

Утас: 99746363 Цахим хаяг: Purevtsetsega@audit.gov.mn

Аудитор Н.Дашмягмар

Утас: 99164665 Цахим хаяг: Dashmyagmam@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу.



Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон улсын стандарт
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ГНАГ	Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗӨСТ	Зооноз өвчин судлалын төв
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУУГ	Монгол Улсын Засгийн газар
СӨХ	Сургуулийн өмнөх боловсрол
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ҮАГ	Үндэсний аудитын газар
ШБУ	Шударга байдлын үнэлгээ
ЭМТ	Эрүүл мэндийн төв

Хүснэгтийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Цалин, нэмэгдэлийн судалгааг салбараар	16
Хүснэгт 2	2019-2024 оны байдлаар Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан албан хаагчдын судалгаа	24
Хүснэгт 3	Төрийн албан хаагчийн хүйсийн харьцаа, жендерийн үзүүлэлтийн судалгаа	25
Хүснэгт 4	Төрийн албан хаагчийн жендерийн үзүүлэлтийг албан тушаалаар харуулсан байдал	26
Хүснэгт 5	Төрийн албанд 2019-2023 онд ажилласан ХБИ-ны судалгаа	27
Хүснэгт 6	Аймгийн хэмжээнд хурдан системийн үйлчилгээ үзүүлэлтийн байдал	27
Хүснэгт 7	Хэрэглэгчийн үнэлгээнд хамрагдах түүвэр олонлогийн хэмжээ	28
Хүснэгт 8	Салбараар үнэлгээ өгсөн байдал	28

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Төрийн байгууллагыг салбараар ангилан хүйсээр нь харьцуулсан байдал	6
2	Төрийн албан хаагчийн ажилласан жилийн байдал	6
3	Төрийн албан хаагчийн ангиллаар харуулсан байдал	6
4	Төрийн байгууллагыг салбараар ангилан Төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн тоотой харьцуулсан байдал	7
5	Санал асуулгад хамрагдсан байдал /салбараар/	7
6	Хүний нөөцийн асуудлыг зохицуулж буй хөтөлбөрийн үзүүлэлт	9
7	Хүний нөөцийн хүрэлцээний байдал /салбараар/	10
8	Хүний нөөцийн хүрэлцээний байдал /салбараар/	10
9	Хүний нөөцийн хүрэлцээний байдал /салбараар/	11
10	Хүний нөөцийн хүрэлцээний байдал /салбараар/	11
11	Хүний нөөцийн хүрэлцээний байдал /салбараар/	12
12	Санал асуулгын дүн	12



13	Төрийн албаны зөвлөлийн тогтоолын хэрэгжилт	14
14	Тэтгэмж урамшуулал 2013-2023 оноор	15
15	Санал асуулгын дүн	16
16	Тусгай шалгалтын сонгон шалгаруулалтын байдал	18
17	Төрийн албан хаагч сургалтад хамрагдсан байдал	22
18	Аймгийн Засаг даргын харьяа байгууллагын дотоод, гадаад сургалт	22
19	Эрүүл мэндийн салбарын сургалтад хамрагдсан албан хаагч	23
20	Соёлын салбарын сургалтад хамрагдсан албан хаагч	23
21	Эрүүл мэндийн салбарын сургалтад хамрагдсан албан хаагч	23
22	Санал асуулгын дүн	24
23	Санал асуулгын дүн	29
24	Вeб сайтыг хөгжүүлэлтийн байдал	30
25	Шударга байдлын үнэлгээ	31



Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудит
хийсэн
үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Ерөнхий Аудиторын “Төрийн аудитын байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай” А/152, “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2023 оны А/162, “Аудитын сэдэв батлах тухай” 2023 оны А/100 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын
зорилт

“Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө”-д гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэв.

Дээрх зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, хууль эрх зүйг хэрэгжүүлэх тогтолцоо бүрдсэн эсэх;
- Төрийн байгууллагуудын хүний нөөцийн тогтолцоо нь сайн засаглалыг бий болгож байгаа эсэх;

Аудитын
хамарсан хүрээ

Аудитад төрийн зорилт, чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлдэг төрийн бодлого боловсруулах, төрөөс зайлшгүй үзүүлэх шаардлагатай бусад үйлчилгээг орон нутаг дахь иргэдэд хүргэх үйл ажиллагаа явуулдаг бүтэц, зохион байгуулалттай аймаг, сумын нутгийн өөрөө удирдах 20, аймгийн Засаг даргын харьяаны төрийн захиргааны 26, боловсролын салбарт харьяалагдах сургууль, цэцэрлэг 64, эрүүл мэндийн салбарт харьяалагдах 18 сумын ЭМТ, соёлын салбарт харьяалагдах 18 сумын Соёлын төв нийт 146 байгууллагын хүний нөөцийн бодлогыг оновчтой зөв тодорхойлсон, боловсруулж хэрэгжүүлсэн байдлыг 2013 оноос 2024 оны есдүгээр сарыг хүртэлх хугацааг хамруулав.

Улсын төсвөөс санхүүждэг “босоо” удирдлагатай 29 байгууллагын хүний нөөцийн бүтэц, өөрчлөлт, төрийн албан хаагчийн дэлгэрэнгүй судалгааг 2023 оноор гаргуулан авч нэгтгэн Үндэсний аудитын газрын ГНАГ-т хүргүүлээ.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-3:2020, 6817-5:2020, 6817-7:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудит, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандартын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардлагатай бүх төрлийн нотлох баримтыг үндэслэн тулган баталгаажуулалт хийж, холбогдох албан тушаалтнаас асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг горимыг хэрэгжүүлж, асуудлын шинжилгээ, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.



Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд: ✓ Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль; ✓ Төрийн албаны тухай хууль; ✓ Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль; ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль; ✓ Байгууллагын нууцын тухай хууль; ✓ Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль; ✓ Захиргааны ерөнхий хууль; ✓ Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль; ✓ Монгол Улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль; ✓ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль; ✓ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль; ✓ Төрийн болон албаны нууцын тухай хууль; ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль; ✓ Төсвийн тухай хууль; ✓ Хөдөлмөрийн тухай хууль; ✓ Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль; ✓ Шилэн дансны тухай хууль; ✓ Төрийн байгууллагын хүний нөөцийн бусад холбогдох эрх зүйн актууд
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа хянан удирдаж, аудитын менежер Д.Нэргүйбаатар үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн ажилласан бөгөөд ахлах аудитор Г.Цог-Эрдэнэ, аудитор Н.Энхчимэг, А.Пүрэвцэцэг, Н.Дашмягмар нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2024.09.05-2024.11.20-ны хооронд хийж гүйцэтгэлээ.
Хүндрэл бэрхшээл	Аудитад 2012-2024 оныг хамруулан үзсэн ба тухайн үед ажиллаж байсан хүний нөөц болон санхүү хариуцсан албан тушаалтнууд солигдсон, санхүүгийн баримт материалууд байгууллагын архивд авагдаагүй, хариуцах эзэнгүй гэсэн шалтгаанаар 39 байгууллагын 2012-2016 оны хүний нөөцтэй холбоотой нэгдсэн судалгааг гаргах боломжгүй, аудитын горим сорил хэрэгжүүлэхэд хүндрэл бэрхшээлтэй байлаа.



Үндсэн мэдээлэл


Архангай аймгийн хэмжээнд 2023 оны байдлаар нутгийн өөрөө удирдах 20 байгууллагад 62, аймгийн Засаг даргын харьяаны 26 байгууллагад 531, боловсролын салбарын харьяа ЕБС, СӨБ-ын 64 байгууллагад 2751, эрүүл мэндийн салбарын харьяа 18 сумын эрүүл мэндийн төвд 516, соёлын салбарын харьяа 18 сумын Соёлын төвд 158 нийт 146 байгууллагад 4017 төрийн албан хаагч ажилласан байна.

Дүрслэл 1. Төрийн байгууллагыг салбараар ангилан албан хаагчдын хүйсээр нь харьцуулсан байдал

Аймгийн хэмжээнд 2023 оны байдлаар ажиллаж байсан нийт 4017 төрийн албан хаагчийн 71.7 хувь буюу 2882 эмэгтэй, 28.3 хувь буюу 1136 нь эрэгтэй албан хаагч байна.



Дүрслэл 2. Төрийн албан хаагчийн ажилласан жилийн байдал



Төрийн байгууллагын 4017 албан хаагчийн 25.8 хувь нь 0-5 жил, 35.9 хувь нь 6-15 жил, 34.2 хувь нь 16-31 жил, 4 хувь нь 32 жилээс дээш тогтвор суурьшилтай ажиллаж байна.

Дүрслэл 3. Төрийн албан хаагчийг ангиллаар харуулбал:

Төрийн байгууллагын салбараар албан хаагчийг албан тушаалын ангиллаар авч үзвэл: Нийт төрийн албан хаагчийн 85.2 хувь буюу 3425 албан хаагч төрийн үйлчилгээнд, 3.6 хувь буюу 147 албан хаагч улс төрийн, 6.1 хувь буюу 246 албан хаагч төрийн захиргааны албан тушаалд ажилласан байна.



Аудитад хамрагдсан 5 салбарын 146 төрийн байгууллагад 2019 оноос 2023 оны хооронд ажиллаж байсан төрийн албан хаагчийн тоог харьцуулж доорх графикаар харууллаа. Графикаас харахад 2019 онд 3703 албан хаагч ажиллаж байсан бол 2023 онд 9.2 хувиар буюу 315 албан хаагчаар нэмэгдэж 4017 албан хаагч болсон байна.



Дүрслэл 4. Төрийн байгууллагыг салбараар ангилан
Төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн тоотой харьцуулсан байдал



Судалгаанаас өмнөх 2019 оныг гүйцэтгэлийг 2023 онтой харьцуулахад боловсролын салбар нь 4.9 хувиар, Засаг даргын харьяа байгууллага нь 4.4 хувиар, нутгийн өөрөө удирдах байгууллага 41.2 хувиар, соёлын салбар 28.8 хувиар төрийн албан хаагчид өссөн харин эрүүл мэндийн салбар 1.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Аудитын хүрээнд 5 салбарын 146 байгууллагын нийт албан хаагчдын 36.7 хувь буюу 1473 төрийн албан хаагчдаас төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, нийгмийн хамгаалал, удирдах албан тушаалтнуудын удирдах арга барил, чадамж, төрийн үйлчилгээний хүртээмж, иргэдэд хүргэх хэлбэр, сургалтад хамрагдаж буй байдлын талаар санал асуулгыг авч нэгтгэн аудитын тайланд тусгасан болно.

Дүрслэл 5. Санал асуулгад хамрагдсан байдал /салбараар/



Санал асуулгад оролцсон нийт албан хаагчдын 47 хувь буюу 691 боловсролын, 23 хувь буюу 337 эрүүл мэндийн, 19 хувь буюу 273 төрийн захиргааны, 8 хувь буюу 122 соёлын, 3 хувь буюу 50 нутгийн өөрөө удирдах байгууллагын албан хаагчид эзэлж байна.

Аудитын тайланг дэд зорилтоор бүлэг болгон танилцуулж байна.



БҮЛЭГ 1. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨТӨЛБӨРИЙГ БАТЛААГҮЙ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ТОГТОЛЦОО БҮРДЭЭГҮЙ БАЙНА

1.1. АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨТӨЛБӨРИЙГ БОЛОВСРУУЛЖ БАТЛААГҮЙ БАЙНА

1.1.1. Аймгийн хэмжээнд төрийн албан хаагчийн хүний нөөцийн бодлого төлөвлөлт, хөтөлбөрийг боловсруулаагүй тул урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцсэн эсэхийг үнэлэх боломжгүй байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21¹ дүгээр зүйлийн 21.1.6-д “аймгийн хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөр”-ийг батлуулж хэрэгжүүлэх чиг үүрэгтэй гэж заасан.

Архангай аймгийн хэмжээнд 2013-2024 оны хагас жилийн байдлаар төрийн албан хаагчийн хүний нөөцийн бодлого төлөвлөлт, хөтөлбөрийг боловсруулж батлуулаагүй байна.

Аудитаас Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан чиг үүргийн хүрээнд аймгийн хэмжээний төрийн албан хаагчийн хүний нөөцийн бодлого төлөвлөлт хөтөлбөрийг боловсруулж батлан мөрдүүлэх арга хэмжээ авах зөвлөмжийг аймгийн ИТХ болон Засаг даргад хүргүүлээ.

1.1.2. Аудитад хамрагдсан төрийн байгууллагууд нь хүний нөөцийн бодлого төлөвлөлтөд дотоод журам, хүний нөөцийн хөгжлийн болон багшийн хөгжлийн хөтөлбөрөөр зохицуулж байна


Аймгийн хэмжээнд төрийн албан хаагчийн хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийн хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулж батлуулаагүй тул төрийн байгууллагууд хүний нөөцийн бодлогын асуудлыг дотоод журам, хүний нөөцийн хөгжлийн болон багшийн хөгжлийн хөтөлбөрийг мөрдөн ажиллаж байна.

Аудитаар боловсролын салбарын харьяа 64 ЕБС, СӨБ-ийн байгууллагуудаас түүвэрлэн 23, эрүүл мэндийн салбарын харьяа 18 сумын эрүүл мэндийн төвөөс түүвэрлэн 11, соёлын салбарын харьяа 18 сумын Соёлын төвүүдээс түүвэрлэн 11, аймгийн Засаг даргын харьяаны 26 байгууллагаас түүвэрлэн 18, нутгийн өөрөө удирдах байгууллагын харьяа 20 байгууллагаас түүвэрлэн 12 нийт 75 байгууллагын хүний нөөцийн бодлого, нөөц бүрдүүлэлт, сонгон шалгаруулалт, гүйцэтгэлийн удирдлага, сургалт, шагнал урамшуулал, сахилга хариуцлага, ажлаас гарах үйл явцад checklist хөтөлж үнэлгээ өгч ажиллалаа.

¹ “Аймгийн чиг үүрэг”



Дүрслэл 6. Хүний нөөцийн асуудлыг зохицуулж буй хөтөлбөрийн үзүүлэлт



Түүвэрт хамрагдсан байгууллагын 54 хувь буюу 41 байгууллага нь дотоод журмаар, 31 хувь буюу 23 байгууллага нь багшийн хөгжлийн хөтөлбөрөөр, 15 хувь буюу 11 байгууллага нь хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд хүний нөөцийн асуудлаа шийдвэрлэж байна.

1.1.3. Аймгийн хэмжээнд хүний нөөцийн бодлогын баримт бичиг боловсруулаагүй байна

Архангай аймгийн хэмжээнд 2013-2024 оны хагас жилийн байдлаар төрийн албан хаагчийн хүний нөөцийн бодлого төлөвлөлт, хөтөлбөрийг боловсруулаагүй тул байгууллагуудын олон талын уялдаа холбоо хангагдсан эсэх асуудалд хариулт өгөх боломжгүй байна.

1.1.4. Төрийн албаны хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд хяналт-үнэлгээ хийгдээгүй байна

1.2. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХҮРЭЛЦЭЭГҮЙ БАЙДАЛ НЬ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИД НӨЛӨӨЛЖ БАЙНА

1.2.1. Аудитад хамрагдсан 146 төрийн байгууллагуудын хүний нөөцийн хүрэлцээ 97.8 хувьтай байна.

Аймгийн хэмжээнд 2023 оны байдлаар 5 салбарын 146 байгууллагад 4107 орон тоо баталсан ба гүйцэтгэлээр 97.8 хувь буюу 4017 албан хаагч ажиллажээ. Салбар бүрээр 2013-2023 оны байдлаарх хүний нөөцийн гүйцэтгэлийг авч үзвэл:

Боловсролын салбар: Боловсролын салбарын 64 ЕБС, СӨБ-ийн байгууллагын төрийн албан хаагчийн 2013 онд 577 орон тооны дутагдалтай байсан бол 2023 оны байдлаар 180 орон тоо болж 68.8 хувиар буурчээ.

Аймгийн хэмжээнд 2024-2025 оны хичээлийн жилд боловсролын салбарт математикийн багш-7, физик багш-1, хими багш-3, мэдээлэл зүй багш-1, биологийн багш-1, англи хэлний багш-3, технологийн багш-1, газарзүй багш-1, дуу хөгжмийн багш-3 нийт 21 багшийн дутагдалтай ажиллаж байна.

Дүрслэл 7. Хүний нөөцийн хүрэлцээний байдал /салбараар/





Эрүүл мэндийн салбар: аймгийн 18 сумын Эрүүл мэндийн төвийн хүний нөөцийн хүрэлцээ 2013 онд нийт 138 орон тооны дутагдалтай байсан бөгөөд 2023 оны байдлаар 12 болж 91.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Хэдий эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хүрэлцээ хангалттай түвшинд байгаа боловч хөдөө орон нутагт ажиллах хүүхдийн эмч, дотрын болон эх барих эмэгтэйчүүдийн эмч, багийн эмч зэрэг нарийн мэргэжлийн эмч байнгын дутагдалтай байна.

Дүрслэл 8. Хүний нөөцийн хүрэлцээний байдал /салбараар/



Соёлын салбар: аймгийн 18 сумын Соёлын төвийн байгууллагуудын хүний нөөцийн хүрэлцээ 2013 онд 1 орон тооны дутагдалтай байсан бол 2023 оны байдлаар 4 орон тоо болж 0.25 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Соёлын салбарын хувьд хүний нөөц хүрэлцээтэй байгаа боловч мэргэжлийн хүний нөөцийн хувьд хомсдолтой байна. Соёлын салбарт номын санч-35, орон нутаг судлах танхимын ажилтан-38, бүжгийн багш-24, хөгжмийн багш-38, техникч-9 нийт 144 албан тушаалын орон тоонд мэргэжлийн бус хүн ажиллаж байна.

Дүрслэл 9. Хүний нөөцийн хүрэлцээний байдал /салбараар/



Төрийн захиргаа: Аймгийн Засаг даргын харьяа 26 аймаг, сумдын ЗДТГ, бусад төсвийн байгууллагуудын хүний нөөцийн хүрэлцээ 2013 онд 12 орон тооны дутагдалтай байсан бол 2023 оны байдлаар 11.5 орон тоо болж 0.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.



Дүрслэл 10. Хүний нөөцийн хүрэлцээний байдал /салбараар/

Аймгийн засаг даргын харъяа агентлагууд хүний нөөцийн хүрэлцээ



Нутгийн өөрөө удирдах байгууллага: Аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллагын харъяа аймаг, сумын ИТХ-ын 20 байгууллагын хүний нөөцийн хүрэлцээ 2013-2023 онуудад хангалттай байна. МУЗГ-ын 2021 оны 376 дугаар тогтоолоор нутгийн өөрөө удирдах байгууллагын бүтэц орон тоог нэмэгдүүлэн баталсан бөгөөд нэмэгдүүлсэн тухай бүр нь аймгийн төрийн албаны салбар зөвлөлөөс тусгай шалгалтыг зохион байгуулж нөхөн томилж ажиллажээ.

Дүрслэл 11. Хүний нөөцийн хүрэлцээний байдал /салбараар/

Нутгийн өөрөө удирдах байгууллагын хүний нөөцийн хүрэлцээ



1.2.2. Төрийн байгууллагын үйлчилгээ нь иргэдэд ил тод нээлттэй байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд “Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгана” гэж заасан байна.

Аймгийн хэмжээнд аудитад хамруулсан байгууллагаас түүвэрлэн 75 байгууллагын үйлчилгээний ил тод нээлттэй байдлыг 2023 оны байдлаар тулган шалгахад аймаг, сумын ИТХ, ЗДТГ-ын 40 байгууллага нь албан ёсны веб сайтаар, боловсрол, эрүүл мэнд, соёлын салбарын байгууллагууд нь facebook хуудасны пэйж



хаягаар дамжуулан төрийн байгууллагын үйлчилгээг иргэдэд ил тод мэдээлсэн байна.

Аудитаар 2375 албан хаагчдаас “Танай байгууллага үйл ажиллагаагаа иргэдэд ямар хэлбэрээр хүргэдэг вэ? гэсэн санал асуулгыг авч нэгтгэв.

Дүрслэл 12. Санал асуулгын дүн



Санал асуулгад оролцсон нийт төрийн албан хаагчдын 69.5 хувь буюу 1070 пэйж хуудсаар, 29.3 хувь буюу 451 нь веб сайтаар, 26.9 хувь буюу 415 нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр, 25.4 хувь буюу 391 нь бусад хэлбэрээр байгууллагын үйл ажиллагаагаа иргэдэд нээлттэй хэлбэрээр хүргэдэг гэсэн хариултыг өгчээ.

Санал асуулгын дүнгээс харахад 2020 оноос эхлэн цахим технологи идэвхтэй хөгжсөн, байгууллага бүр өөрийн пэйж хаягтай болж иргэд, олон нийтэд үйлчилгээгээ цаг тухай бүрд нь цахимаар мэдээлэн ажиллаж байна.

1.3. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРИМ УДИРДЛАГУУД НЬ ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРГИЙН ДАГУУ ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭЭГҮЙ БАЙНА

1.3.1. Эрх бүхий байгууллагаас төрийн зарим байгууллагын чиг үүрэгт шинжилгээ хийж, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэх шаардлагатай байна.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 22 дугаар тогтоолоор баталсан “Чиг үүрэг дахин батлах тухай аргачлал”-ын дагуу аймгийн хэмжээнд төрийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг 2019 оны 2 дугаар улиралд шинэчлэн баталжээ.

Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А/175 дугаар тушаалаар Нэгдсэн эмнэлэг, ЗӨСТ, сумын ЭМТ-ийн дарга нарын албан тушаалын тодорхойлолтыг баталсан ба 2023, 2024 онуудад салбарын хуулиудад нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотойгоор албан тушаалын тодорхойлолтод шинэчлэл хийгдээгүйгээс шалтгаалан 2024 оны 11 дүгээр сарын байдлаар Нэгдсэн эмнэлгийн дарга болон Хотонт, Хашаат, Эрдэнэмандал, Цэцэрлэг, Тариат, Цэнхэр сумын эрүүл мэндийн төвийн даргын сул орон тооны сонгон шалгаруулалтыг төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулаагүй байна.


Аудитаар Эрүүл мэндийн салбарын хууль тогтоомжийн нэмэлт өөрчлөлттэй уялдуулан удирдах албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж ТАЗ-өөр батлуулах саналыг ЯАГ-аар уламжлуулан ЭМЯ-нд хүргүүлээ.



Төрийн албаны зөвлөлөөс 2021, 2023 онуудад аймгийн төрийн захиргааны байгууллагын зарим удирдах, гүйцэтгэх албан хаагчдын сонгон шалгаруулах, томилох үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 2021 онд 12 байгууллагын 79, 2023 онд 13 байгууллагын 28 нийт давхардсан тоогоор 25 байгууллагын 107 зөрчилтэй албан хаагчийг томилсон шийдвэрийг хүчингүй болгох тухай Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 09 дүгээр сарын 29-ны 242 тогтоол, 2024 оны 04 дүгээр сарын 25-ны 173 дугаар тогтоолуудыг Төрийн албаны аймгийн салбар зөвлөл болон шалгадагч байгууллагуудад хүргүүлсэн байна. Аудитаар тогтоолын хэрэгжилтийг нотлох баримтад үндэслэн үнэлэхэд 2024 оны 9 сарын байдлаар хэрэгжилт 92.7 хувьтай байна.

Дүрслэл 13. Төрийн албаны зөвлөлийн тогтоолын хэрэгжилт

Төрийн албаны зөвлөлийн хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил



Төрийн албаны салбар зөвлөл нь 2013-2024 оны хагас жилийн байдлаар төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого төлөвлөлтөд хяналт шалгалт хийгээгүй байна. /Эх сурвалж: Төрийн албаны салбар зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 16-ны 102 дугаар албан бичиг/

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын "Чиглэл хүргүүлэх тухай" 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн ХЭГ/595 дугаар албан бичгээр "Шүүр" ажиллагааг хэрэгжүүлэх 11 чиглэлийн хүрээнд удирдах албан тушаалд 27, төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалд 52, төрийн үйлчилгээний албан тушаалд 26 нийт 105 иргэнийг хууль бусаар томилсон зөрчлийг ирүүлсэн байна. Аймгийн төрийн албаны салбар зөвлөлийн 2024 оны 3 дугаар сарын хэрэгжилтийн тайлангаар нийтийн албан тушаалаас чөлөөлөгдсөн 60, албан тушаалаас чөлөөлөгдөхөөс бусад байдлаар 20 нийт 80 зөрчлийг арилгаж хуулийн дагуу шийдвэрлэсэн байна. Аудитын явцад зөрчил арилаагүй 25 албан хаагчийг хянан шалгахад 14 албан хаагчтай холбоотой зөрчлийг хуулийн дагуу шийдвэрлэсэн ба 2024 оны 11 сарын



байдлаар "Шүүр" ажиллагааны хэрэгжилт 48 хувьтай байна. Төрийн албаны салбар зөвлөлтэй холбоотой 8, Эрдэнэмандал сумын ЕБС-2, Өлзийт сумын Соёлын төв-2, Хашаат сумын ЕБС-тэй холбоотой 1 нийт 11 зөрчил арилаагүй байна.

Аудитын илрүүлэлт:

- ✓ Төрийн албаны зөвлөлийн тогтоолын хэрэгжилт 92.7 хувьтай байгаа нь Монгол улсын Их хурлын 2019 оны 2 дугаар сарын 01-ний 17 дугаар тогтоолоор баталсан Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрмийн "3.1.3.б² заалттай нийцэхгүй байна.
- ✓ Төрийн албаны салбар зөвлөл нь аймгийн Засаг даргын харьяа төрийн байгууллагуудын хүний нөөцийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийгээгүй нь Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 09 дүгээр сарын 04-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 3.6.2³¹ 3.6.4⁴ дэх заалттай нийцэхгүй байна.
- ✓ "Шүүр" ажиллагааны хэрэгжилт 48 хувьтай байгаа нь Монгол Улсын Их хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 17 дугаар тогтоолоор баталсан Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрмийн "3.1.3.б заалттай нийцэхгүй байна.

Аудитаас Төрийн албаны зөвлөлийн тогтоолын хэрэгжилтийг хангуулах, аймгийн Засаг даргын харьяаны төрийн байгууллагуудад Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, "Шүүр" ажиллагааны хэрэгжилтийг ханган үр дүнг тооцож ажиллах зөвлөмжийг аймгийн Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлээ.

- ✓ Аудитын хүрээнд 2012-2024 оны төрийн байгууллагын хүний нөөц, нийгмийн баталгаа, цалин урамшуулал, нэмэгдлийг дэлгэрэнгүй судалгаагаар төрийн байгууллагуудаас гаргуулахад явцад хариуцаж байсан албан тушаалтан солигдсон, шилжсэн гэх шалтгаанаар 39 байгууллагын 2012-2016 оны санхүүгийн болон хүний нөөцийн баримт материал архивд байхгүй, үүний улмаас аудитад шаардлагатай баримт мэдээллийг гаргаж ирүүлээгүй болно.

Энэ нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.1⁵, 24 дүгээр зүйлийн 24.1.9⁶, 35 дугаар зүйлийн 35.4.7⁷ дахь заалттай нийцэхгүй байна.

Аудитаас Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж хүний нөөц болон санхүүтэй холбоотой баримт материалыг архивын нэгж үүсгээгүй 39 байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтөд хяналт тавьж үр дүнг тооцож ажиллах албан шаардлагыг аймгийн ЗДТГ-ын дарга, архивын тасгийн дарга нарт хүргүүлээ.

² Маргаан хянан шийдвэрлэсэн Зөвлөлийн шийдвэрийг биелүүлэх талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд хугацаатай үүрэг даалгавар өгөх, биелэлтийг хангуулах;

³ Хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд Төрийн албаны зөвлөлөөс баталсан аргачлал, удирдамжийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

⁴ Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих

⁵ 23.2.1-д "албан хэрэг хөтлөлтийн явцад үүссэн хавтаст баримтыг зохион байгуулалтын нэгж, ажилтнаас бүрэн бүрдэлтэй хүлээн авах"

⁶ 24.1.9-д "архивын баримтын хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт тавих"

⁷ 35.4.7-д баримт бичгийг байгууллагын архивд бүрэн бүрдэлтэй шилжүүлэх



1.3.2. Төрийн албан хаагчийг тогтвор суурьшилтай ажиллуулах нийгмийн баталгааг хангах арга хэмжээг хэрэгжүүлж байна

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд төрийн албаны шинэчлэлийг орон нутагт эрчимжүүлэх зорилгоор “Төрийн албан хаагчдын хөгжлийн хөтөлбөр”-ийг боловсруулсан байна. Үүний хүрээнд төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл 20 хувийг олгохоор 2023 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс аймгийн ИТХ-аар батлуулан мөрдөж ажилласан байна.

Аймгийн Засаг даргын харьяа нийт 146 байгууллагын 4,017 албан хаагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар тухайн онд олгосон цалин хөлс, нэмэгдэл, тэтгэмж урамшууллын нэгдсэн судалгааг гаргахад үндсэн цалинд 5,533.5 сая төгрөг, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл 675.1 сая төгрөг, онцгой нөхцлийн нэмэгдэлд 74.6 сая төгрөг, зэрэг дэвийн нэмэгдэлд 66.9 сая төгрөг, мэргэшлийн нэмэгдэлд 118.7 сая төгрөг, боловсролын зэргийн нэмэгдэлд 38.1 сая төгрөг, орон нутгийн нэмэгдэлд 1,122.7 сая төгрөг, хоол унааны нэмэгдэлд 99.3 сая төгрөг, бусад нэмэгдэлд 382.5 сая төгрөг нийт 8,111.5 сая төгрөгийг олгожээ. /Эх сурвалж: Төрийн албан хаагчийн нэгдсэн судалгаа/

Хүснэгт 1. Цалин, нэмэгдэлийн судалгааг салбараар харуулбал: /сая төгрөгөөр/

№	Салбар	Байгуу- л- лагын тоо	Албан хааг- чийн тоо	Үндсэн цалин	Төрийн алба хаасан хугаца а	Онцго й нөхцө л	Нэмэгдэл						Нийт цалин нэмэгдэ л
							Зэрэг дэв	Мэргэш -лийн	Болов сролы н зэрги йн	Орон нутгийн	Унаа хоол	Бусад нэмэгдэ л	
1	Нутгийн өөрөө удирдах	20	62	100.8	9.8	9.8	8.8	0.5	-	35.5	0.9	8.1	174.3
2	Эрүүл мэнд	18	516	569.4	60	7.3	2.9	4.5	-	113.5	45.8	39.5	842.8
3	Боловс рол	64	2750	4,060.6 0	546.4	4.8	15.1	109.1	38.1	772.6	15.7	295.6	5,858.00
4	Соёл	18	158	153.6	14.8	-	-	-	-	9.5	-	6.6	184.6
5	Төрийн захирга а	26	531	649.1	44.1	52.7	40	4.6	-	191.6	36.9	32.7	1,051.80
Нийт дүн		146	4017	5,533.5 0	675.1	74.6	66.9	118.7	38.1	1,122.7 0	99.3	382.5	8,111.50

Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад аймгийн Засаг даргын харьяа төрийн албан хаагчдад 2013 оноос 2023 оны байдлаар нийт тэтгэмж урамшуулал давхардсан тоогоор 6,953 албан хаагчдад 21,845.3 сая төгрөгийг олгосон байна. Тэтгэмж урамшуулал 2013 онд нийт 487 албан хаагчид 1,395.1 сая төгрөгийг олгож байсан бол 2023 онд 870 албан хаагчид 3,428.4 сая төгрөгийг тэтгэмж урамшуулалд олгосон ба суурь онтой харьцуулбал албан хаагчийн тоо 55.9 хувь, мөнгөн дүн 40.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Боловсролын салбарын тухайд 2013-2023 оны байдлаар 3 болон 5 жил ажилласны тэтгэмжид зориулж 11,504.4 сая төгрөгийг олгожээ.




Дүрслэл 14. Тэтгэмж урамшуулал 2013-2023 оноор

Тэтгэмж урамшуулал 2013-2018 он



Тэтгэмж урамшуулал 2019-2023 он



Аудитад хамрагдсан байгууллагын 1541 албан хаагчдаас “төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа хангагдаж байна уу” гэсэн санал асуулгыг авахад 77.9 хувь нь урамшуулал, 65.3 хувь нь тэтгэмжийг хууль журмын дагуу хугацаанд нь авч байгаа гэсэн байна. Судалгаанд оролцогчдын 64.9 хувь нь буцалтгүй тусламж авч байгаагүй гэсэн хариултыг өгсөн байна.

Дүрслэл 15. Санал асуулгын дүн






1.3.3. Төрийн байгууллагын зарим томилох эрх бүхий албан тушаалтнууд нь сул орон тооны захиалгыг Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлээгүй байна

Төрийн албаны ерөнхий шалгалтад 2021-2023 онд нийт 1157 хүн оролцож 409 хүн тэнцэж, төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн байна.

Дүрслэл 16. Тусгай шалгалтын сонгон шалгаруулалтын байдал

Төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх, төрийн үйлчилгээний удирдах албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг аймгийн салбар зөвлөлд ирүүлсэн захиалгын дагуу 2022-2024 оны хагас жилийн байдлаар давхардсан тоогоор нийт 724 сул орон тоог зарлаж хууль журмын дагуу сонгон шалгаруулалт зохион байгуулан дунджаар 31.9 хувь буюу 231 албан тушаалын сул орон тоог нөхсөн байна.



Аудитын илрүүлэлт:

- ✓ 2016-2023 онуудад Аймгийн Засаг дарга нь Худалдан авах ажиллагааны газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга нарын сул орон тооны захиалгыг Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлэх үүргээ хэрэгжүүлээгүй.
- ✓ 2023-2024 онд Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нь ИТХ-ын Нарийн бичгийн даргын сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх үүргээ хэрэгжүүлээгүй.
- ✓ 2023-2024 онд Ихтамир сумын Засаг дарга нь Соёлын төвийн даргын сул орон тооны захиалгыг аймгийн Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлэх үүргээ хэрэгжүүлээгүй.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1⁸, 27.2⁹ дахь заалттай нийцэхгүй байна.

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2 дахь заалтын хэрэгжилтийг хангаж удирдах албан тушаалтны сул орон тооны сонгон шалгаруулалт явуулах захиалгыг төрийн албаны зөвлөл болон аймгийн салбар зөвлөлд хүргүүлэх албан шаардлагыг аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга, болон Ихтамир сумын Засаг дарга нарт хүргүүлээ.

⁸ 27.1.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий этгээд доор дурдсан журмын дагуу уг орон тоог нөхнө:

⁹ Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ.



- ✓ Хангай сумын ЕБС-ийн сэтгэл зүйч, Эрдэнэмандал сумын ЕБС-ийн номын санч, хүүхдийн цэцэрлэгийн явуулын багш Эрдэнэмандал сумын Сум дундын ойн ангийн ойн инженерийн орон тоонд албан тушаалын тодорхойлолтод заасан ерөнхий шаардлага хангаагүй 4 албан хаагч ажиллаж байна.

Энэ нь Төрийн албан зөвлөлийн 2019 оны тогтоолоор баталсан жишиг албан тушаалын тодорхойлолтын ерөнхий шаардлагыг хангаагүй байна.

Албан тушаалын тодорхойлолтын ерөнхий шаардлага хангасан албан хаагчийг томилох арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг Хангай сумын ЕБС-ийн захирал, Эрдэнэмандал сумын ЕБС-ийн захирал, Эрдэнэмандал сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч, Эрдэнэмандал сумын Сум дундын ойн ангийн дарга нарт хүргүүлээ.

- ✓ Хангай сумын ЗДТГ-ын 12, Эрдэнэмандал сум дахь Сум дундын ойн ангийн 5, Өлзийт сумын ЗДТГ-ын 12, Боловсролын салбарын харьяаны Хайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 11, Цэцэрлэг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 17, Эрүүл мэндийн салбарын Цэцэрлэг сумын ЭМТ-ийн 3, Хайрхан сумын ЭМТ-ийн 4 нийт 64 албан хаагчийн хувийн хэргийн иж бүрдэл дутуу байна.

Энэ нь Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолын "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын 1 дүгээр хавсралтын 1.4¹⁰, 5.2-5.5 дахь заалттай нийцэхгүй байна.

Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолын "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын 1 дүгээр хавсралтын 1.4, 5.2-5.5 дахь заалтын хэрэгжилтийг хангаж төрийн албан хаагчийн хувийн хэргийн иж бүрдлийг хангуулах арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг дарга, Боловсролын газар, Эрүүл мэндийн газрын дарга нарт хүргүүлээ.

- ✓ Төрийн албаны салбар зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 01/1203 дугаар тогтоолын хавсралтаар сумын Соёлын төвийн дарга нарын албан тушаалын жишиг тодорхойлолтыг баталсан хэдий ч Батцэнгэл, Цахир, Хашаат, Хангай, Өгийнуур, Чулуут, Жаргалант, Өлзийт Цэнхэр сумдын Засаг дарга нар Соёлын төвийн дарга нарын албан тушаалын тодорхойлолтыг шинэчилж батлаагүй, хувийн хэргийн иж бүрдэл дутуу байгаа нь Төрийн Албаны Зөвлөлийн 600 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын 1 дүгээр хавсралтын 1.4, 5.2-5.5 дахь заалттай нийцэхгүй байна.

¹⁰ 1.4.Хувийн хэрэг нь төрийн албан хаагчийн хувийн болон түүний боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, ажлын үр дүн, шагнал урамшуулал, бүтээл туурвил, ажлын туршлагатай холбоотой мэдээллийг агуулсан төрийн албаны хүний нөөцийн удирдлагын бүртгэл, судалгаа, төлөвлөлтийн үндсэн баримт бичиг байна.



Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолын "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын хэрэгжилтийг ханган 9 сумын Соёлын төвийн дарга нарын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэх, хувийн иж бүрдлийг хангуулах арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг сумын Засаг дарга нарт хүргүүллээ.

1.3.4. Аймгийн хэмжээнд албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас төрд учруулсан 27.9 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлээгүй байна

Аймгийн хэмжээнд 2016-2023 оны байдлаар Шүүгчийн шийдвэрээр давхардсан тоогоор 19 төрийн албан хаагчийн ажилгүй байсан хугацааны цалин, хөлс болон нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд нийт 100.1 сая төгрөгийг хариуцагч байгууллагаас гаргуулж барагдуулахаар шийдвэрлэжээ.

Аудитаар төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтийн байдалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхэд төрийн албан хаагчтай холбоотой 3 хариуцагч 15.7 сая төгрөгийг төсөвт буцаан төлсөн ба (5.4 сая төгрөгийг шүүхийн шийдвэрийн дагуу төсөвт буцаан төвлөрүүлэх) арга хэмжээ авагдсан, 2 нэхэмжлэгчийг эвлэрлээр буцаан ажилд нь томилсон байна. Харин 6 төрийн албан хаагчтай холбоотой хариуцагч нь нас барсан 50.9 сая төгрөгийн хохирлыг ТАЗ-өөс хэрэгсэхгүй болгожээ. /Эх сурвалж: Төрийн албаны зөвлөлийн тогтоол/

Шүүхийн шийдвэрээр тогтоогдсон нэхэмжлэхийн дагуу байгууллагын төсвөөс нөхөн төлбөрийг олгож төрд хохирол учруулсан 2017-2019 оны аймгийн Засаг даргатай холбоотой 2 нэхэмжлэгчтэй холбоотой 16.9 сая төгрөг, 2022-2023 оны 1 нэхэмжлэгчтэй Цэнхэр сумын Сум дундын Ойн ангийн даргатай холбоотой 7.8 сая төгрөг, 2018 оны 1 нэхэмжлэгчтэй Өгийнуур сумын ЕБС-ийн захиралтай холбоотой 2.9 сая төгрөг, 2018 оны 1 нэхэмжлэгчтэй Эрдэнэбулган сумын ЗДТГ-ын даргатай холбоотой 0.5 сая төгрөгийн нийт 7 албан хаагчтай холбоотой 27.9 сая төгрөгийг барагдуулах арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 50.2¹¹ заалттай нийцэхгүй байна.

Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2 дахь заалтын хэрэгжилтийг хангаж 27.9 сая төгрөгийн төрд учруулсан хохирлыг барагдуулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг аймгийн Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүллээ.

1.3.5. Төрийн албан хаагчийн нэгдсэн тоо бүртгэлийн мэдээллийн санг бүрдүүлсэн хэдий ч төрийн байгууллагуудын мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавих тогтолцоо бүрдээгүй байна

¹¹ 50.2.Төрийн албаны төв байгууллага шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргана.



Аймгийн Төрийн албаны салбар зөвлөл, боловсрол, эрүүл мэнд, соёлын салбарын бодлого хэрэгжүүлэгч байгууллагууд нь төрийн албаны зөвлөлийн <https://hrm.csc.gov.mn/> хүний нөөцийн удирдлага мэдээллийн системээр дамжуулан тухайн салбарын байгууллагын мэдээллийг дэлгэрэнгүй байдлаар харах, нэгтгэл хийх, системд оруулсан хүний нөөцийн мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавих боломжгүй байна.

Төрийн албаны зөвлөлийн <https://hrm.csc.gov.mn/> хүний нөөцийн удирдлага мэдээллийн системээр дамжуулан ТАЗ болон бусад салбарын бодлого хэрэгжүүлэгч байгууллагууд нь анхан шатны нэгжийн байгууллагуудтай уялдаа холбоотой ажиллах чиглэлээр системийн хөгжүүлэлтийг хийх саналыг ҮАГ-аар уламжлуулан ТАЗ-д хүргүүлэв.

БҮЛЭГ 2. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

2.1. ИРГЭНДЭЭ ҮЙЛЧИЛДЭГ ТӨРИЙН АЛБА БИЙ БОЛОХ НӨХЦӨЛ БҮРДЭЖ БАЙНА

2.1.1. Төрийн албан хаагчдыг орон зайнаас үл хамааруулан сургаж байна

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 299 дүгээр тогтоолоор “Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхээр баталжээ. Төрийн албаны тухай хуулийн 33 зүйлийн 33.6-д “Төрийн байгууллага нь дараах хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ”, 33.6.1-д “Төрийн албан хаагчийн сургалт” гэж заасны дагуу аймгийн ЗДТГ-ын даргын 2018 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн А/10 дугаар тушаалаар “Төрийн албан хаагчийн сургалтын дэд хөтөлбөр”-ийг 3 зорилт 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулж баталсан бөгөөд хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг байгууллагын дарга нарт үүрэг болгосон боловч аймгийн хэмжээнд 2018-2020 онуудад хэрэгжилтийг тайлагнаагүй, үр дүнг тооцоогүй байна.

Төрийн байгууллагаас 2021-2024 оны эхний хагас жилийн байдлаар төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор 218 байгууллагын давхардсан тоогоор 5506 төрийн албан хаагчийг сургалтад хамруулсан байна. Тухайлбал: төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтад 286, мэргэжлийн багц сургалтад 115, хууль тогтоомж, бодлогын хэрэгжилт, мэргэжлийн чадварыг дээшлүүлэх сургалтад 5105 төрийн албан хаагчийг хамруулсан байна. Эх сурвалж: /аймгийн Төрийн албаны салбар зөвлөлийн 2021-2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан/



Дүрслэл 17. Төрийн албан хаагч сургалтад хамрагдсан байдал



/Эх сурвалж: Аймгийн Төрийн албаны салбар зөвлөлийн тайлан/

Аймгийн хэмжээнд 2012-2023 оны байдлаар аудитад хамрагдсан 5 салбарын 146 төрийн байгууллагын 1356 төрийн албан хаагчийг мэдлэг чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр гадаад, дотоодын сургалтад хамруулж 162.9 сая төгрөгийн санхүүжилтийг төсвөөс олгосон байна. /Эх сурвалж: Төрийн албан хаагчийн нэгдсэн судалгаа/

Төрийн захиргаа:

Аймгийн Засаг даргын харьяа 26 байгууллагууд нь 2012-2023 онд дотоод сургалтад 83 төрийн албан хаагчийг хамруулж 77.1 сая төгрөгийн, гадаад сургалтад 8 төрийн албан хаагчийг хамруулж 7.5 сая төгрөгийн нийт 84.6 сая төгрөгийг байгууллагын төсвөөс зарцуулжээ.

Дүрслэл 18. Аймгийн Засаг даргын харьяа байгууллагын дотоод, гадаад сургалт



Эх сурвалж: /Төрийн албан хаагчийн нэгдсэн судалгааны дүн/

Судалгаанаас харахад нутгийн өөрөө удирдах 20 байгууллагын давхардсан тоогоор 62 албан хаагчийг 2012-2023 онд дотоод сургалтад хамруулж төсвөөс 1.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Эрүүл мэндийн салбар:

Аймгийн хэмжээнд судалгаанд хамрагдсан эрүүл салбарын харьяа 18 сумын Эрүүл мэндийн төвүүд нь 2012-2023 онд үндсэн болон төрөлжсөн, мэргэжил дээшлүүлэх, давтан сургалтуудад давхардсан тоогоор 924 төрийн албан хаагчийг хамруулж, сургалтын зардлыг улсын төсвөөс шийдвэрлэжээ.



Дүрслэл 19. Эрүүл мэндийн салбарын сургалтад хамрагдсан албан хаагч



Эх сурвалж: /Төрийн албан хаагчийн нэгдсэн судалгааны дүн/

Соёлын салбар:

Аймгийн хэмжээнд соёлын салбарын харьяа байгууллагууд нь 2012-2023 оны байдлаар нийт 35 албан хаагчдыг сургалтад хамруулсан бөгөөд байгууллагын төсвөөс сургалтын зардлын дэмжлэг үзүүлээгүй байна.

Дүрслэл 20. Соёлын салбарын сургалтад хамрагдсан албан хаагч



Эх сурвалж: /Төрийн албан хаагчийн нэгдсэн судалгааны дүн/

Харин 2024 оны байдлаар аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.5 дахь зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд соёл, урлагийн чиглэлээр Их дээд сургуульд суралцаж байгаа сумдын соёлын төвийн албан хаагчид аймгийн Засаг даргын 2024 оны А/701 дугаар захирамжаар 10.0 сая төгрөгийн сургалтын зардлын дэмжлэг үзүүлсэн байна.

Боловсролын салбар:

Боловсролын салбарын албан хаагчдыг ажилласан жилээс хамааруулан дунд болон богино хугацааны, үндсэн, төрөлжсөн мэргэжлийн сургалтад хамруулдаг бөгөөд 2012-2023 оны байдлаар 279 төрийн албан хаагчийг төрийн сангийн зардлаар суралцуулан 84.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

Дүрслэл 21. Эрүүл мэндийн салбарын сургалтад хамрагдсан албан хаагч

Боловсролын салбарын дотоод сургалтын судалгаа



Эх сурвалж: /Төрийн албан хаагчийн нэгдсэн судалгааны дүн/



Төрийн албаны тухай хуулийн 24, 29 дүгээр зүйлд заасны дагуу аймгийн хэмжээнд 2019-2024 оны эхний хагас жилийн байдлаар Удирдлагын академийн 4 төрлийн сургалтад 270 төрийн албан хаагч суралцаж 78.2 хувь буюу 211 нь төгссөн бөгөөд сургалтын зардалд улсын төсвөөс 327.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Үлдсэн 59 албан хаагчийн 19 нь 2021-2022 суралцсан боловч төгсөөгүй бөгөөд улсын төсвөөс сургалтын зардалд 31.2 сая төгрөгийг олгосон нь үр дүнгүй зарцуулагдсан байна. Төлбөрийг буцаан төлүүлэх талаар суралцагчтай байгуулсан гэрээнд тодорхой тусгаагүй тул барагдуулах боломжгүй болсон байна.


Хүснэгт 2. 2019-2024 оны байдлаар Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан албан хаагчдын судалгаа

№	Огноо	Чиглүүлэх сургалт	Дунд шатны давтан	Ахлах түшмэл	Эрхэлсэн түшмэл	Үүнээс	
						Төгссөн	Сурч буй
1	2019				2	2	
2	2020	7	10	64	1	82	
3	2021	12	11	6	1	30	7
4	2022	8	7	16	1	32	12
5	2023	6	13	14	2	35	11
6	2024	7	14	7	2	30	29
Дүн		40	55	107	9	211	59

Эх сурвалж: /Нэгдсэн судалгааны дүн/

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотой 2019-2024 онд нийт 211 төрийн албан хаагч, үүнээс 40 албан хаагчийг чиглүүлэх багц сургалтад, 55 албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны болон давтан сургалтад, 107 албан хаагч ахлах түшмэл сургалтад тус тус хамрагдсан байна.

Дүрслэл 22. Санал асуулгын дүн



Аудитаар 5 салбарын хэмжээнд нийт төрийн албан хаагчдын 37.9 хувь буюу 1523 төрийн албан хаагчаас “Орон зайнаас үл хамааран сургалтад хамрагдаж чадаж байна уу” гэж асуухад 79.9 хувь буюу 1217 төрийн албан хаагч “тийм”, 20.1 хувь буюу 306 төрийн албан хаагч “үгүй” гэж хариулсан байна.

Санал асуулгын дүнгээс харахад “Орон зайнаас үл хамааран сургалтад төрийн албан хаагчид хамрагдаж чадаж байна” гэж үзэхээр байна.

2.1.2. Аймгийн хэмжээнд 2013-2023 оны байдлаар төрийн албан хаагчийг сэлгэн шилжүүлэн ажиллуулаагүй байна

Төрийн албаны тухай хуулийн 44 зүйлийн 44.1-т¹² Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 34/31 дүгээр хамтарсан тушаалын хавсралтаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-д заасны дагуу төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах эрх зүйн орчин бүрдсэн ч аймгийн хэмжээнд аудитад хамруулсан байгууллагуудын тухайд 2012-2023 онд

¹²44.1. үндэслэн төрийн жинхэнэ албан хаагчтай тохиролцож, эсхүл тухайн байгууллагад 10 ба түүнээс дээш жил нэг албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчийг удирдлагын санаачилгаар төрийн албаны нэг байгууллагаас нөгөө байгууллагад тэдгээрийн удирдлагын хооронд харилцан тохиролцсоны дагуу шилжүүлэн ажиллуулж болно.



мэргэшсэн төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадвар ашиглах, дадлага туршлагыг бусдад эзэмшүүлэх зорилгоор өөр албан тушаалд шилжүүлэн болон сэлгэн ажиллах томилгоо хийгдээгүй байна.

Харин аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн Б/43 дугаар тушаалаар Хангай сумын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтнийг аймгийн ЗДТГ-ын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтнээр шилжүүлэн томилжээ. /Эх сурвалж: Аймгийн ЗДТГ-ын анхан шатны баримтаас/

2.1.3. Аймгийн хэмжээнд 2023 оны байдлаар төрийн байгууллагын жендерийн тэнцвэртэй байдлыг хангаж байна

Монгол Улсын Жендерийн тэгш байдлыг хангах тухай хуульд заасны дагуу аймгийн ИТХТ-ийн 2020 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн 40 дүгээр тогтоолоор аймгийн жендерийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг 3 зорилт 6 шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр баталсан бөгөөд аймгийн Засаг даргын 2020 оны 2 дугаар сарын 21-ны өдрийн А/130 дугаар захирамжаар жендерийн тэгш байдлыг хангах аймгийн салбар хороог байгуулж, хорооны ажиллах журмыг баталжээ.

Аймгийн ЗДТГ-ын хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсээс жил бүр хяналт шинжилгээ үнэлгээг хийсэн ба үнэлгээний тайлангаас харахад 2020 онд 48.4 хувь, 2021 онд 62.8 хувь, 2022 онд 97.8 хувь, 2023 онд 95.7 хувиар тус тус үнэлжээ.

Жендерийн эрх тэгш байдлын хэрэгжилтийг аймгийн хэмжээний 146 төрийн байгууллагын 4017 төрийн албан хаагчийн хүйсийн тэнцвэрт байдалд дүн шинжилгээ хийхэд нийт төрийн албан хаагчийн 71.7 хувь буюу 2880 нь эмэгтэй, 28.3 хувь буюу 1137 нь эрэгтэй албан хаагч эзэлж байна. /Эх сурвалж: Төрийн албан хаагчийн нэгдсэн судалгаа/

Хүснэгт 3. Төрийн албан хаагчийн хүйсийн харьцаа, жендерийн үзүүлэлтийн судалгаа

№	Албан тушаалын ангилал	Нийт албан хаагчийн тоо	Хүйс		Эрэгтэй албан хаагчийн эзлэх хувь	Эмэгтэй албан хаагчийн эзлэх хувь
			Эрэгтэй	Эмэгтэй		
1	Улс төрийн	147	127	20	86.4	13.6
2	Төрийн захиргаа	246	99	147	40.2	59.8
3	Тусгай	4	4		100	
4	Үйлчилгээ	3620	907	2713	25.1	74.9
	Нийт дүн	4017	1137	2880	100	100
	Албан хаагчийн эзлэх дундаж хувь		28.3%	71.7%		

/Эх сурвалж: Төрийн албан хаагчийн нэгдсэн судалгаа/

Аймгийн хэмжээний 5 салбарын 146 төрийн байгууллагын 4017 төрийн албан хаагчийн жендерийн харьцааг салбараар авч үзвэл дараах байдалтай байна.

- ✓ Нутгийн өөрөө удирдах байгууллагын хүйсийн харьцаа нь эрэгтэй 46.8 хувь буюу 29, эмэгтэй 53.2 хувь буюу 33, аймгийн Засаг даргын харьяа төрийн захиргааны байгууллагын тухайд эрэгтэй 58.6 хувь буюу 311, эмэгтэй 41.3 хувь буюу 220 төрийн албан хаагч эзэлж байгаа ба аль нэг хүйс давамгайлаагүй байна.
- ✓ Соёлын салбарын харьяа 18 сумын Соёлын төвийн хэмжээнд 58.2 хувь буюу 92 эмэгтэй, 41.7 хувь буюу 66 эрэгтэй албан хаагч эзэлж байгаа ба аль нэг хүйс давамгайлаагүй байна.



Дээрх салбарууд нь Жендерийн эрх тэгш байдлын тухай хуулийн 10 зүйлийн 10.3¹³ дахь заалттай нийцэж байна.

- ✓ Эрүүл мэндийн салбарын харьяаны 18 сумын Эрүүл мэндийн төвийн нийт албан хаагчдын 80.3 хувь буюу 415 эмэгтэй, 19.7 хувь буюу 101 эрэгтэй, боловсролын салбарын харьяа 64 ЕБС, СӨБ-ийн байгууллагын нийт албан хаагчдын 77.1 хувь буюу 2121 эмэгтэй, 22.9 хувь буюу 629 эрэгтэй албан хаагч эзэлж байгаа боловч Жендерийн эрх тэгш байдлын тухай хуульд 6.5.1, 6.5.6-д заасан нэг хүйсийн онцлог хэрэгцээнд нийцсэн эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ үзүүлэх байгууллага тул хуулийн 60:40 харьцаанд хамаарахгүй байна.

Хүснэгт 4. Төрийн албан хаагчийн жендерийн үзүүлэлтийг албан тушаалаар харуулбал

№	Салбар	Байгуул агын тоо	Албан тушаалын төрөл						Нийт албан хаагчийн тоо	
			Удирдах		Гүйцэтгэх		Туслах			
			Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм
1	Нутгийн өөрөө удирдах	20	24	14	4	18	1	1	29	33
2	Эрүүл мэнд	18	10	6	21	309	70	100	101	415
3	Боловсрол	64	17	89	295	1415	318	616	629	2121
4	Соёл	18	6	12	16	47	44	33	66	92
5	Төрийн захиргааны	26	112	19	140	163	59	38	311	220
	Нийт дүн	146	169	140	476	1952	492	788	1137	2880

/Эх сурвалж: Төрийн албан хаагчийн нэгдсэн судалгаа

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 17 зүйлийн 17.3¹⁴, Хөдөлмөрийн тухай хуулийн 144 зүйлийн 144.2¹⁵ дахь заалтын хүрээнд аймгийн хэмжээний 5 салбарын 146 байгууллагын хэмжээнд 2019-2023 оны байдлаар давхардсан тоогоор 560 хөгжлийн бэрхшээлтэй иргэн төрийн албанд ажиллажээ.

Төрийн байгууллагын хүний нөөцийн нэгдсэн судалгаанаас харахад 2019 онд 16.6 хувь буюу 93, 2020 онд 18.6 хувь буюу 104, 2021 онд 20 хувь буюу 112, 2022 онд 22.3 хувь буюу 125, 2023 онд 20.5 хувь буюу 126 хөгжлийн бэрхшээлтэй иргэн төрийн албанд ажилласан байна. 2023 оны гүйцэтгэлийг 2019 онтой харьцуулахад 35.5 хувь буюу 33 албан хаагчаар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 5. Төрийн албанд 2019-2023 онд ажилласан ХБИ-ны судалгаа

Огноо	Салбар	НДШ төлж байгаа нийт албан хаагчдын тоо	ХБИ-тэй албан хаагчийн тоо	Хувь
2019	5	3703.5	93	16.6
2020	5	3799.5	104	18.5
2021	5	3849.5	112	20.0
2022	5	3864.5	125	22.3
2023	5	4017	126	22.5
Дүн		19234	560	100.0

Эх сурвалж: Аудитын нэгдсэн судалгаа

¹³ Төрийн ба төсөвт байгууллагын нийт ажилтны дунд аль нэг хүйсийн төлөөлөл илт давамгайлсан тохиолдолд хүйсийн 40:60 гэсэн харьцаа бүхий тэнцвэрт байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх бодлого, арга хэмжээг хүний нөөцийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх бөгөөд энэ хуулийн 6.5.6-д заасан тохиолдолд энэ заалт үл хамаарна" гэж заасныг хангаж байна.

¹⁴ 17.3. "Төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний бие эрхтэн, хөгжлийн онцлогт нийцсэн ажлын байрыг Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу бий болгож ажиллуулах үүрэгтэй"

¹⁵ 144.2. "Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 25 ба түүнээс дээш ажилтантай ААНэгж, байгууллага нийт ажлын байрныхаа 4%-аас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулна"



2.2. ИРГЭД ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ОРОН ЗАЙНААС ҮЛ ХАМААРАН АВАХ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛЖ ЭХЭЛСЭН БАЙНА

2.2.1. Цахим технологи ашиглан иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх шат дамжлага буурсан байна

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 499 дүгээр тогтоолоор Засгийн газрын хэрэглэгч агентлаг-Төрийн цахим үйлчилгээний зохицуулах газрыг байгуулсан. Тус газраас төрийн үйлчилгээний шат дамжлага, хүнд суртлыг бууруулах, цаг хугацаа, зардал хэмнэх, цаасан хэрэглээг багасгах, үйлчилгээг хурдан шуурхай хүргэх, цахим хэлбэрт шилжүүлж, төрийн үйлчилгээг нэг цэгээс авах боломжийг бүрдүүлэх зорилгоор Улсын хэмжээнд "Хурдан" төрийн үйлчилгээний цахим системээс 2023 оны 5 дугаар сараас эхлэн 43 байгууллагын 790 үйлчилгээг авах боломжтой болсон байна.

Хүснэгт 6. Аймгийн хэмжээнд хурдан системийн үйлчилгээ үзүүлэлтийн байдал

№	Огноо	Төрөл	Орон нутгийн хэмжээнд Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн операторын горимоор үзүүлсэн үйлчилгээ			Аймгийн хэмжээний "Хурдан" цэгийн үйлчилгээ	Эрдэнэбулган сумын хэмжээний "Хурдан" цэгийн үйлчилгээ
			Лавлагаа	Нэг шатлал	Олон шатлал		
1	2023	Операторын үйлчилгээ				6,342	4,242
		Зөвлөгөө, мэдээлэл					1,241
		Лавлагааны тоо	5,772	68	508		
		Нийт дүн	5,772	68	508	6,342	5,483
2	2024	Операторын үйлчилгээ				29,643	13,776
		Зөвлөгөө, мэдээлэл					5,526
		Лавлагааны тоо	29,492	852	1,194		
		Нийт дүн	29,492	852	1,194	29,643	19,302

Аймгийн хэмжээнд "ХУРДАН" төрийн үйлчилгээний цахим системээс 2023 онд Орон нутгийн хэмжээнд төрийн цахим үйлчилгээний хэлтсийн операторын горимоор лавлагаа 5772, нэг шатлал 68, олон шатлал 508 нийт 6348 үйлчилгээг авсан бол 2024 онд лавлагаа 29492, нэг шатлал 852, олон шатлал 1194 нийт 31538 үйлчилгээг үзүүлж өмнөх оноос 83.2 хувиар өссөн байна.

Аудитын илрүүлэлт:

Аймгийн хэмжээнд 2023 онд 2 ТӨҮГ, 10 төрийн байгууллагын 39 үйлчилгээг "ХУРДАН" системээр авахаар 247 иргэн, ААНБ-аас хүсэлт ирүүлсэн хэдий ч тухайн байгууллагууд нь шийдвэрлээгүй байна.

Энэ нь Төрийн албан тухай хуулийн 37 зүйлийн 37.1.12-т "...төрийн үйлчилгээг чирэгдэлгүйгээр чанартай, хүртээмжтэй, шуурхай, соёлтой хүргэх, төрийн үйлчилгээг хүргэх ..." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаас Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж иргэд, ААН-ээс цахимаар үйлчилгээ авахаар ирүүлсэн хүсэлтийг цаг тухай бүр нь шийдвэрлэх арга хэмжээг авч, хэрэгжилтийг үнэлж, үр дүнг тооцож ажиллах албан шаардлагыг аймгийн ЗДТГ-ын дарга болон төрийн цахим үйлчилгээний хэлтсийн даргад хүргүүлээ.



2.2.2. Орон нутагт төрийн үйлчилгээг иргэдэд тэгш хүртээмжтэй хүргэх шаардлагатай байна

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 20 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Засгийн Газрын Хэрэг Эрхлэх газрын 2017 оны 12 дүгээр сарын 15-ны өдрийн 302 дугаар тогтоолоор баталсан удирдамжийн дагуу “GRAND DATA” ХХК-с Архангай аймгийн төрийн байгууллагын үйлчилгээ нь хэрэглэгчдэд чанартай, хүртээмжтэй хүнд сурталгүй шуурхай үйлчилж буй эсэхэд 2023 оны байдлаар судалгаа хийж дүгнэсэн байна.

Хэрэглэгчийн үнэлгээний судалгаанд Архангай аймгийн төвийн 450, сумын 391 нийт 841 хэрэглэгч түүврээр судалгаанд оролцсон байна.

Хүснэгт: 7 Хэрэглэгчийн үнэлгээнд хамрагдах түүвр олонлогийн хэмжээ

Аймгийн нэр	Түүврийн нэгж	Эх олонлог	Түүвр олонлог
Аймгийн төв			450
Сумын төв	Иргэн	64772	391
Дүн			841

/Эх сурвалж: Архангай аймгийн төрийн үйлчилгээний 2023 оны үйл ажиллагааны хэрэглэгчийн үнэлгээ хийсэн судалгааны тайлангаас/

Хүснэгт 8. Салбараар үнэлгээ өгсөн байдал


Салбарын чиг үүрэг	Үнэлгээ
Эрүүл мэнд	3.34
Боловсрол, спорт, соёл	3.42
Нийтийн тээвэр	3.04
Дэд бүтэц, хот тохижилт	2.83
Аюулгүй байдал, шударга ёс	3.26
Ажил эрхлэлт, нийгмийн даатгал	3.26
Батлан хамгаалах	3.36
Улсын бүртгэл	3.77
Засаглал	3.16
ХЭРЭГЛЭГЧИЙН ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ	3.29

Судалгааны дүгнэлтээр Аймгийн ЗДТГ-аас 2023 онд хэрэгжүүлж буй төрийн үйлчилгээг 9 үндсэн салбар бүхий чиг үүргийн дагуу 56 хүчин зүйлээр, сэтгэл ханамжийн үнэлгээг тооцож үзэхэд хэрэглэгчдийн дундаж үнэлгээ нь 3.29 хувь буюу “ДУНДАЖ” гэж дүгнэгдсэн байна.

Судалгааны дүгнэлт: Архангай аймгийн

төрийн үйлчилгээний бүхий л салбарт нь 2.82-3.77 гэсэн онооны хооронд үнэлэгдсэн байгаа тул **“төрийн үйлчилгээг жигд удирдлагаар хангаж ажиллах, олон шатлалт арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх, улмаар хэрэглэгчийн сэтгэл хангамжийг өсгөх”** шаардлагатай гэж дүгнэсэн байна. Эх сурвалж: /GRAND DATA ХХК-ны 2023 оны судалгааны тайлан/

Дүрслэл 23. Санал асуулгын дүн



Аудитад хамрагдсан байгууллагын 1529 төрийн албан хаагчдаас “Таны бодлоор орон нутагт төрийн үйлчилгээ иргэдэд жигд хүртээмжтэй хүрч чадаж байна уу” гэсэн санал асуулгаар 58.6 хувь буюу 896 төрийн албан хаагч “**тийм**”, **41.4** хувь буюу **633** төрийн албан хаагч “**үгүй**” гэж хариулсан байна. Санал асуулгын дүнгээс харахад орон нутагт төрийн үйлчилгээ иргэдэд жигд хүртээмжтэй хүрч чадахгүй байна.



2.3. АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ИЛ ТОД БАЙДАЛД ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА

2.3.1. Төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа уялдаа холбоотой ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд 2023 оны байдлаар боловсролын салбарын харьяа 64 ЕБС, СӨБ соёлын салбарын харьяа 18 сумын Соёлын төв, эрүүл мэндийн салбарын харьяа 18 сумын Эрүүл мэндийн төвүүд нь тухайн салбарын хуулиар бодлого хэрэгжүүлэгч байгууллагаас чиг үүрэг, үйл ажиллагаанд нь чиглэл өгч уялдаа холбоотой ажиллаж байна.

Мөн аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллагын харьяа 20 байгууллага, аймгийн Засаг даргын харьяа 26 байгууллагууд нь <https://erp.e-mongolia.mn> цахим системийг ашиглан хоорондоо мэдээллийг харилцан солилцож ажиллаж байна.

2.3.2. Төрийн үйлчилгээний ил тод нээлттэй байдалд холбогдох байгууллагууд судалгаа болон хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллагын харьяа 20, Засаг даргын харьяаны 26, эрүүл мэндийн салбарын 18, боловсролын салбарын 64, соёлын салбарын 18 нийт 146 байгууллагын 2327 төрийн албан хаагчдаас төрийн байгууллагын үйлчилгээг иргэдэд ямар хэлбэрээр нээлттэй хүргэж байгаа эсэхэд санал асуулга авч нэгтгэн дүгнэж үзэхэд нийт санал асуулгад оролцогчдын 69.5 хувь 1070 албан хаагчид байгууллагын facebook хуудасны пэйж хаягаар, 29.3 хувь буюу 451 албан хаагчид байгууллагын веб хуудсаар, 26.9 хувь буюу 415 албан хаагчид хэвлэл мэдээллийн хэрэгслээр, 25.4 хувь буюу 391 албан хаагч бусад хэлбэрээр төрийн үйлчилгээг иргэдэд ил тод нээлттэй хүргэдэг гэсэн хариултыг өгчээ.

Дүрслэл 24. Веб сайтын хөгжүүлэлтийн байдал

Аудитаар нутгийн өөрөө удирдах байгууллагын харьяа аймаг, сумын ИТХ-ын 20 байгууллагын веб сайт <http://arkhangai.khural.mn> хөгжүүлэлт, мэдээлэл байршуулалт, хандалтын байдлыг 2021-2024 оны байдлаарх тоон дүнг дүрслэлээр харуулбал: Мэдээлэл байршуулалт өмнөх 2023 оноос 1903-р буурсан, хандалт хийсэн хүний тоог 2021 онтой харьцуулбал 2024.10 сарын байдлаар 58.5 хувиар буюу 133,385 болж өссөн байна.



Аудитын илрүүлэлт:

- ✓ Аймаг, сумдын ИТХ-ын <http://arkhangai.khural.mn> вэб сайтад мэдээлэл байршуулсан болон хандалтыг байдлыг 2021-2024 оны байдлаар судалгаа хийж үзэхэд Хангай сумын ИТХ нь мэдээлэл огт байршуулаагүй байна.



Аудитаас Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалтын хэрэгжилтийг хангаж сумын ИТХ-ын ажлын албаны вэб сайт хөтлөлтийг сайжруулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг авч үр дүнг тооцож ажиллах зөвлөмжийн аймгийн ИТХ-д хүргүүлээ.

- ✓ Аймаг, сумдын ЗДТГ-ын <http://Arkhangai.gov.mn> вэб сайтад мэдээлэл байршуулсан болон хандалтыг байдлыг 2023 оны 05 дугаар сараас 2024 оны 11 дүгээр сарын байдлаар тулган шалгахад аймгийн ЗДТГ болон 19 сумдын ЗДТГ-ууд нь байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг цаг тухай бүр байршуулж иргэд, олон нийтэд мэдээлээгүй байна.

Энэ нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2¹⁶ дахь заалттай нийцэхгүй

Аудитаас Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалтын хэрэгжилтийг хангаж аймгийн ЗДТГ болон сумдын ЗДТГ-ын албаны вэб сайтын хөтлөлт болон хөгжүүлэлтийг сайжруулах, мэдээлэл байршуулалтад хяналт тавьж үр дүнг тооцож ажиллах албан шаардлагыг аймгийн ЗДТГ-ын даргад хүргүүлээ.

2.3.3. Аймгийн ЗДТГ нь шударга байдлын үнэлгээгээр 70 буюу өмнөх оноос 2.0 оноогоор өсөж ахиц дэвшил гарсан байна.

Монгол Улсын хэмжээнд Авлигатай тэмцэх газрын захиалгаар 2019, 2021, 2022 онуудад шударга байдлын үнэлгээг судалгааны 2 байгууллагаар хийж гүйцэтгүүлсэн байна. Судалгааны тайлангаас харахад Архангай аймгийн ЗДТГ-ыг хамруулан үйлчилгээ авсан иргэд, ААНБ, тухайн байгууллагад ажиллаж буй албан хаагчид, бодлого боловсруулах төлөвлөх үе шатанд оролцогчдыг хамруулан үнэлгээ хийхэд 2019 онд 73.2, 2021 онд 68, 2022 онд 70 оноогоор үнэлэгдсэн байна.

Дүрслэл 25. Шударга байдлын үнэлгээ



Судалгааны тайлангаас харахад 2019 онд аймгийн ЗДТГ-ын шударга байдлын үнэлгээ 73.2 байгаа нь тухайн байгууллагад ажиллаж буй албан хаагчдаас авсан дотоод ШБҮ өндөр байгаагаас нөлөөлсөн байна. 2021 оны ШБҮ 68 болж өмнөх оноос 5.2 оноогоор буурсан нь төрийн үйлчилгээ авсан иргэд, ААНБ-ыг хамруулсан гадаад ШБҮ огцом буурсантай холбоотой байна.

Харин 2022 оны тухайд ШБҮ 70 буюу 2021 онтой харьцуулахад 2.0 оноогоор өссөн нь төрийн үйлчилгээ иргэдэд тэгш, хүртээмжтэй хүрэхэд ахиц

¹⁶ 8.2-д "Мэдээлэл хариуцагч өөрийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана"



дэвшил гарсныг харуулж байна. /Эх сурвалж: "Эм Эм Си Жу" ХХК-ны 2019 оны шударга байдлын үнэлгээний тайлан, "Эс Ай Си Эй" ХХК-ны 2021, 2022 оны шударга байдлын үнэлгээний тайлан/

Шударга байдлын үнэлгээ өссөнөөр авлигын индекс нь буурдаг урвуу хамааралтай байна.



АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- ✓ Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого төлөвлөлт, хөтөлбөрийг батлаагүйгээс хэрэгжүүлэх тогтолцоо бүрдээгүй байна
- ✓ Төрийн байгууллагын зарим удирдлагууд нь хуулиар хүлээсэн чиг үүргийн дагуу хүний нөөцийн асуудлыг шийдвэрлээгүй байна
- ✓ Эрх бүхий байгууллагаас төрийн зарим байгууллагын чиг үүрэгт шинжилгээ хийж, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэх шаардлагатай байна.
- ✓ Төрийн байгууллагуудын хүний нөөцийн тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай байна
- ✓ Иргэд төрийн үйлчилгээг орон зайнаас үл хамааран авах боломжийг бүрдүүлж эхэлсэн байна
- ✓ Аймгийн хэмжээнд албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас төрд учруулсан 27.9 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлээгүй байна
- ✓ Аймгийн хэмжээнд 2023 оны байдлаар төрийн байгууллагын жендерийн тэнцвэртэй байдлыг хангаж байна
- ✓ Аймгийн хэмжээнд төрийн үйлчилгээний ил тод байдалд хяналтыг хэрэгжүүлээгүй байна
- ✓ Аймгийн хэмжээнд төрийн үйлчилгээг ил тод нээлттэй хүргэж шударга байдлын үнэлгээ 2.0 оноогоор өссөн байна

АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨТӨЛБӨРИЙГ БОЛОВСРУУЛААГҮЙ, ХЯНАЛТЫН ҮР НӨЛӨӨТЭЙ ТОГТОЛЦОО БҮРДЭЭГҮЙ БАЙНА

Аудитын дүн: Аудитаар нийт 27.9 сая төгрөгийн 30 зөрчил илэрснээс 27.9 сая төгрөгийн 20 зөрчилд 20 албан шаардлага, 8 заалт бүхий зөвлөмжийг аймгийн ИТХ, Засаг дарга, холбогдох байгууллагуудад, 2 саналыг ҮАГ-аар уламжлуулан ТАЗ, ЭМЯ-нд хүргүүлээ.

-----oOo-----



ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна.

Аймгийн ИТХ-ын дарга П.Гомбодоржид

1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан чиг үүргийн дагуу аймгийн хэмжээний төрийн албан хаагчийн хүний нөөцийн бодлого, төлөвлөлт хөтөлбөрийг баталж мөрдүүлэх арга хэмжээ авах
2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалтын хэрэгжилтийг хангаж сумын ИТХ-ын ажлын албаны вэб сайт хөтлөлтийг сайжруулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг авч үр дүнг тооцож ажиллах

Аймгийн Засаг дарга Б.Цэрэннадмидад

3. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан чиг үүргийн хүрээнд аймгийн хэмжээний төрийн албан хаагчийн хүний нөөцийн бодлого, төлөвлөлт хөтөлбөрийг боловсруулж, батлуулах арга хэмжээ авах

Архангай аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Гомбодоржид

4. Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 242, 2024 оны 173 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч үр дүнг тооцож ажиллах
5. Аймгийн Засаг даргын харьяаны төрийн байгууллагуудад Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг тооцож ажиллах
6. Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолын "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын 1 дүгээр хавсралтын 1.4, 5.2-5.5 дахь заалтын хэрэгжилтийг хангаж төрийн албан хаагчийн хувийн хэргийн иж бүрдлийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах

Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга Р.Гандиймаад

7. Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолын "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын 1 дүгээр хавсралтын 1.4, 5.2-5.5 дахь заалтын хэрэгжилтийг хангаж Эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчийн хувийн хэргийн иж бүрдлийг хангуулах арга хэмжээ авч ажиллах

Аймгийн Боловсролын газрын дарга Ц.Мөнхбатад

8. Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолын "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын 1 дүгээр хавсралтын 1.4, 5.2-5.5 дахь заалтын хэрэгжилтийг хангаж боловсролын салбарын төрийн албан хаагчийн хувийн хэргийн иж бүрдлийг хангуулах арга хэмжээ авч ажиллах



Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэсний дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2024 оны 12 дугаарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Зөвлөмжийн биелэлтийг тооцож, нотлох баримтыг хангуулан 2025 оны 09 дүгээр сарын 25-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.



УЛАМЖЛАХ САНАЛ

Аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 01-ны А/175 дугаар тушаалаар Нэгдсэн эмнэлэг, ЗӨСТ, сумын ЭМТ-ийн дарга нарын албан тушаалын тодорхойлолтыг баталсан ба 2023, 2024 онуудад салбарын хуулиудад нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотойгоор албан тушаалын тодорхойлолтод шинэчлэл хийгдээгүй байна. Үүнээс шалтгаалан 2024 оны 11 дүгээр сарын байдлаар Нэгдсэн эмнэлгийн дарга болон Хотонт, Хашаат, Эрдэнэмандал, Цэцэрлэг, Тариат, Цэнхэр сумдын эрүүл мэндийн төвийн даргын сул орон тооны сонгон шалгаруулалтыг төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулаагүй байна.

Санал 1. Эрүүл мэндийн салбарын хууль тогтоомжийн нэмэлт өөрчлөлттэй уялдуулан удирдах албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж Төрийн албаны зөвлөлөөр батлуулах саналыг ҮАГ-аар уламжлуулан ЭМЯ-нд хүргүүлэх

Аймгийн Төрийн албаны салбар зөвлөл, боловсрол, эрүүл мэнд, соёлын салбарын бодлого хэрэгжүүлэгч байгууллагууд нь Төрийн албаны зөвлөлийн <https://hrm.csc.gov.mn/> хүний нөөцийн удирдлага мэдээллийн системээр дамжуулан тухайн салбарын байгууллагын мэдээллийг дэлгэрэнгүй байдлаар харах, нэгтгэл хийх, системийн бүртгэлийн үнэн зөв байдалд хяналт тавих боломжгүй байна. Үүнээс үзэхэд төрийн байгууллагууд хоорондоо мэдээлэл солилцох уялдаа холбоо хангалтгүй байна.

Санал 2. Төрийн албаны зөвлөлийн <https://hrm.csc.gov.mn/> хүний нөөцийн удирдлага мэдээллийн системээр дамжуулан Төрийн албаны салбар зөвлөл болон бусад салбарын бодлого хэрэгжүүлэгч байгууллагууд нь анхан шатны нэгжийн байгууллагуудтай уялдаа холбоотой ажиллах чиглэлээр системийн хөгжүүлэлтийг хийх саналыг ҮАГ-аар уламжлуулан ТАЗ-д хүргүүлэх



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ
АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ САЛБАР ЗӨВЛӨЛ

Нутгийн захиргааны ордон А корпус, 2 дугаар баг
Эрдэнэбулган сум, Архангай аймаг 65139
утас: (976) 7033 2576, Факс: (976) 7033 2576
Цахим шуудан: arkhangaitasz@gmail.com

2024.11.20. № 121
танай 2024.11.20. -ны № 465 -г

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Т. БАЙГАЛМАА ТАНАА

“Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Төсөлд холбогдох санал байхгүй болно.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ГОМБОДОРЖ



Аудитор
Т. Цог-Аюулам

Амжилттай зохионо.

ТАЗСЗ, А5, 2024

0573402212



ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/43

Эрдэнэбулган сум

Гүйцэтгэлийн аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө"-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2.Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

3.Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Төрийн албаны салбар зөвлөл, Эрүүл мэндийн газар, Боловсролын газарт тус тус хүргүүлсүгэй.

4. Аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (Г.Цог-Эрдэнэ), аудитор (А.Пүрэвцэцэг), (Н.Дашмягмар), (Н.Энхчимэг) нарт үүрэг болгосугай.

5.Гүйцэтгэлийн аудитын тайланд тусгагдсан зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Г.Цог-Эрдэнэ), эрх зүйч аудитор (Б.Анхтуяа) нарт даалгасугай.

6.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Д.Нэргүйбаатар)-т үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.БАЙГАЛМАА



Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцоо үр нөлөө

Аудитын код: ГНАГ-2024/19-ШТА-ГА

№	Хүргүүлсэн шийдвэрийн			Хэрэгжилтийг хариуцах		
	Утга	Мөнгөн дүн /мөнгөн төгрөг/	Тоо	Шийдвэр	Байгууллага, албан тушаал	Албан тушаалтны нэр
1	2023-2024 онд Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нь ИТХ-ын Нарийн бичгийн даргын сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх үүргээ хэрэгжүүлсгүй тул албан шаардлага хүргүүлээ	-	1	424	Аймгийн ИТХурал	П.Гомбодорж
2	2023-2024 онд Ихтамир сумын Засаг дарга нь Соёлын төвийн даргын сул орон тооны захиалгыг аймгийн Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлэх үүргээ хэрэгжүүлсгүй тул албан шаардлага хүргүүлээ	-	1	428	Ихтамир сумын Засаг дарга	Б.Цэвээндорж
3	2016-2023 онуудад Аймгийн Засаг дарга нь Худалдан авах ажиллагааны газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга нарын сул орон тооны захиалгыг Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлэх үүргээ хэрэгжүүлсгүй тул албан шаардлага хүргүүлээ	-	1	425	Аймгийн Засаг дарга	Б.Цэрэннадмид
4	Аудитын хүрээнд 2012-2024 оны төрийн байгууллагын хүний нөөц, нийгмийн баталгаа, цалин урамшуулал, нэмэгдлийг дэлгэрэнгүй судалгаагаар төрийн байгууллагуудаас гаргуулахад явцад хариуцаж байсан албан тушаалтан солигдсон, шилжсэн гэх шалтгаанаар 39 байгууллагын 2012-2016 оны санхүүгийн болон хүний нөөцийн баримт материал архивд байхгүй, үүний улмаас аудитад шаардлагатай баримт мэдээллийг гаргаж ирүүлсгүй болно.	-	1	427	Аймгийн ЗДТГазар	Ш.Гомбодорж, Т.Гантуяа
5	Хангай сумын ЕБС-ийн сэтгэл зүйчийн орон тоонд албан тушаалын тодорхойлолтод заасан ерөнхий шаардлага хангаагүй албан хаагч байна.	-	1	429	Хангай ЕБСургууль	И.Атарсайхан
6	Эрдэнэмандал сумын ЕБС-ийн номын санч, орон тоонд албан тушаалын тодорхойлолтод заасан ерөнхий шаардлага хангаагүй албан хаагч байна.	-	1	442	Эрдэнэмандал ЕБС	Д.Сарнайцэцэг
7	Эрдэнэмандал сумын Сум дундын ойн ангийн ойн инженерийн орон тоонд албан тушаалын тодорхойлолтод заасан ерөнхий шаардлага хангаагүй албан хаагч байна.	-	1	440	Эрдэнэмандал ойн анги	Б.Цогбадрах



8	Эрдэнэмандал сумын хүүхдийн цэцэрлэгийн явуулын багш орон тоонд албан тушаалын тодорхойлолтод заасан ерөнхий шаардлага хангаагүй албан хаагч байна.	-	1	441	Эрдэнэмандал Хүүхдийн цэцэрлэг	Б.Буяндэлгэр
9	Төрийн албаны зөвлөлийн 600 дугаар тогтоолын "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын хэрэгжилтийг ханган Батцэнгэл сумын Соёлын төвийн дарга нарын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэх, хувийн иж бүрдлийг хангуулах арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг сумын Засаг даргад хүргүүлээ.	-	1	430	Батцэнгэл сумын Засаг дарга	Ц.Зоригтхүү
10	Төрийн албаны зөвлөлийн 600 дугаар тогтоолын "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын хэрэгжилтийг ханган Хашаат сумын Соёлын төвийн дарга нарын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэх, хувийн иж бүрдлийг хангуулах арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг сумын Засаг даргад хүргүүлээ.	-	1	432	Хашаат сумын Засаг дарга	Д.Дондов
11	Төрийн албаны зөвлөлийн 600 дугаар тогтоолын "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын хэрэгжилтийг ханган Хангай сумын Соёлын төвийн дарга нарын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэх, хувийн иж бүрдлийг хангуулах арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг сумын Засаг даргад хүргүүлээ.	-	1	433	Хангай сумын Засаг дарга	Өрнөхбаяр
12	Төрийн албаны зөвлөлийн 600 дугаар тогтоолын "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын хэрэгжилтийг ханган Өгийнуур сумын Соёлын төвийн дарга нарын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэх, хувийн иж бүрдлийг хангуулах арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг сумын Засаг даргад хүргүүлээ.	-	1	434	Өгийнуур сумын Засаг дарга	Ш.Үүрцайх
13	Төрийн албаны зөвлөлийн 600 дугаар тогтоолын "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын хэрэгжилтийг ханган Чулуут сумын Соёлын төвийн дарга нарын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэх, хувийн иж бүрдлийг хангуулах арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг сумын Засаг даргад хүргүүлээ.	-	1	435	Чулуут сумын Засаг дарга	Э.Анхбаяр
14	Төрийн албаны зөвлөлийн 600 дугаар тогтоолын "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын хэрэгжилтийг ханган Жаргалант сумын Соёлын төвийн дарга нарын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэх, хувийн иж бүрдлийг хангуулах арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг сумын Засаг даргад хүргүүлээ.	-	1	436	Жаргалант сумын Засаг дарга	П.Алтанхуяг
15	Төрийн албаны зөвлөлийн 600 дугаар тогтоолын "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын хэрэгжилтийг ханган Өлзийт сумын Соёлын төвийн дарга нарын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэх, хувийн иж бүрдлийг хангуулах арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг сумын Засаг даргад хүргүүлээ.	-	1	438	Өлзийт сумын Засаг дарга	Г.Баттулга



16	Төрийн албаны зөвлөлийн 600 дугаар тогтоолын "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын хэрэгжилтийг ханган Цахир сумын Соёлын төвийн дарга нарын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэх, хувийн иж бүрдлийг хангуулах арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг сумын Засаг даргад хүргүүлээ.	-	1	431	Цахир сумын Засаг дарга	
17	Төрийн албаны зөвлөлийн 600 дугаар тогтоолын "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын хэрэгжилтийг ханган Өгийнуур сумын Соёлын төвийн дарга нарын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэх, хувийн иж бүрдлийг хангуулах арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг сумын Засаг даргад хүргүүлээ.	-	1	437	Цэнхэр сумын ЗДТГ-ын дарга	Э. Болорцэцэг
18	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан чиг үүргийн хүрээнд аймгийн хэмжээний төрийн албан хаагчийн хүний нөөцийн бодлогын төлөвлөлт хөтөлбөрийг боловсруулж батлан мөрдүүлэх арга хэмжээ авах зөвлөмжийг аймгийн ИТХ болон Засаг даргад хүргүүлээ.	-	2		Аймгийн Засаг дарга Аймгийн ИТХурал	Б. Цэрэннадмид П. Гомбодорж
19	Төрийн албаны зөвлөлийн тогтоолын хэрэгжилтийг хангуулах, аймгийн Засаг даргын харьяаны төрийн байгууллагуудад Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, "Шуур" ажиглаганы хэрэгжилтийг ханган үр дүнг тооцож ажиллах зөвлөмжийг аймгийн Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлээ.	-	1		Аймгийн ТАЗөвлөл	Ш. Гомбодорж
20	Төрийн албаны зөвлөлийн 600 дугаар тогтоолын "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын 1 дүгээр хавсралтын 1.4, 5.2-5.5 дахь заалтын хэрэгжилтийг хангаж төрийн албан хаагчийн хувийн хэргийн иж бүрдлийг хангуулах арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг дарга, Боловсролын газар, Эрүүл мэндийн газрын дарга нарт хүргүүлээ.	-	3		Аймгийн засаг дарга Аймгийн эрүүл мэндийн газар Боловсролын газрын дарга	Б. Цэрэннадмид Р. Ганцгиймаа, Ц. Мөнхбат
21	Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж иргэд, ААН-ээс цахимаар үйлчилгээ авахаар ирүүлсэн хүсэлтийг цаг тухай бүр нь шийдвэрлэх арга хэмжээг авч, хэрэгжилтийг үнэлж, үр дүнг тооцож ажиллах албан шаардлагыг аймгийн ЗДТГ-ын дарга болон төрийн цахим үйлчилгээний хэлтсийн даргад хүргүүлээ.	-	1	439	Аймгийн ЗДТГ-аар	Ш. Гомбодорж
22	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалтын хэрэгжилтийг хангаж сумын ИТХ-ын ажлын албаны вэб сайт хөтлөлтийг сайжруулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг авч үр дүнг тооцож ажиллах зөвлөмжийн аймгийн ИТХ-д хүргүүлээ.	-	1		Аймгийн ИТХурал	П. Гомбодорж
23	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалтын хэрэгжилтийг хангаж аймгийн ЗДТГ болон сумдын ЗДТГ-ын албаны вэб сайтын хөтлөлт болон хөгжүүлэлтийг сайжруулах, мэдээлэл байршуулалтад хяналт тавьж үр дүнг тооцож ажиллах зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын даргад хүргүүлээ.	-	1		Аймгийн ЗДТГ-аар	Ш. Гомбодорж



24	Төрийн албаны зөвлөлийн тогтоолын хэрэгжилтийг хангуулах, аймгийн Засаг даргын харьяаны төрийн байгууллагуудад Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, "Шүүр" ажиллагааны хэрэгжилтийг ханган үр дүнг тооцож ажиллах зөвлөмжийг аймгийн Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлээ.	-	1		Аймгийн ТАЗөвлөл	Ш.Гомбодорж
25	Төрийн албаны тухай хуулийн 50.2 дахь заалтын хэрэгжилтийг хангаж 27.9 сая төгрөгийн төрд учруулсан хохирлыг барагдуулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг аймгийн Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлээ.	27,964.5	1	426	Аймгийн ТАЗөвлөл	Ш.Гомбодорж
	Албан шаардлага	27,964.50	19			
	Зөвлөмж	-	9			
	НИЙТ ДҮН	27,964.50	28			